



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймгийн Түшиг сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СЭА-2024/196/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.selenge@audit.gov.mn Сүхбаатар сум 2024 он	Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа Утас: 70363040 Цахим хаяг: enkhtuyach@audit.gov.mn Аудитын менежер: Б.Батмөнх Утас: 70363036 Цахим хаяг: batmunkhb@audit.gov.mn Аудитыг гүйцэтгэсэн: Их наяд аудит ХХК Захирал: Х.Ариунзул Утас: 99077062 Цахим хаяг: ikhnayadaudit@gmail.com
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. АУДИТЫН ДҮГНЭЛТ	4
2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	6
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	10
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	10
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	11
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд	12
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	13
4. АУДИТЫН ТАЙЛАН	14
4.1 Ерөнхий зүйл	14
4.2 Материаллаг байдал	15
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	15
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	15
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	16
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	17
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	17
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	18

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
БШУС	Боловсрол, шинжлэх ухааны сайд
БШУЯ	Боловсрол, шинжлэх ухааны яам
БЕГ	Боловсролын ерөнхий газар
БШУГ	Боловсрол, шинжлэх ухааны газар
НБББББ	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
МУЕА	Монгол улсын ерөнхий аудитор
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани



СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

II баг, Цагаан эрэг, Сүхбаатар сум,
Сэлэнгэ аймаг, 43081
Утас/Факс: (976)-7036-3040
Цахим шуудан: Selenge@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

СЭЛЭНГЭ АЙМГИЙН ТҮШИГ
СУМЫН 1 ДҮГЭЭР ЦЭЦЭРЛЭГИЙН
ЭРХЛЭГЧ Н.ЭНХРИЙМАА ТАНАА

2024.02.23 № СЭА-2024/196/НА-СТА-ТШЗ
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сэлэнгэ аймгийн Түшиг сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Түшиг сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Түшиг сумын 1 дүгээр цэцэрлэг нь Боловсролын Ерөнхий газрын даргын 2023 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн А/324 дүгээр тушаалаар сургалтын байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээний үр дүнгээр 3 дугаар түвшинд үнэлэгдэж, урамшуулалд 5,475.0 мянган төгрөгийн санхүүжилт авч зарцуулсан байна.

Аудитын гол асуудал

Нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд мөрдөж байгаа Боловсрол, Шинжлэх Ухааны сайдын 2021 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн А/22 дугаар тушаалаар баталсан “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг” нь гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжиж байгаа байгууллагын онцлогт тохироогүй, үр дүнд

018020227

суурилсан төсөвлөлт, санхүүжилт, хөрөнгө оруулалт, хөтөлбөр, арга хэмжээний бүртгэлийн талаар нарийн тусгаагүй байна.

Байгууллагын төсөв, санхүүжилтийг зардлын эдийн засгийн ангиллаар нь бус “бараа үйлчилгээний бусад зардал” гэсэн ангиллаар бөөнд нь тусган, төлөвлөж, баталж байгаа нь төсвийг зардлын бүлэг, зүйлээр төлөвлөж, зарцуулах, зарцуулалтад хяналт тавих зарчмыг алдагдуулж байна.

Бусад асуудлын хэсэг

Тус байгууллага нь тайлант оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 9 зорилтын хүрээнд 20 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, 83.6 хувийн гүйцэтгэлтэй үнэлэгдсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	58,094,621.11	144,540,204.59
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	12,383,734.51	98,068,022.99
311	Кассанд байгаа бэлэн мөнгө	-	-
312	Банканд байгаа бэлэн мөнгө	12,383,734.51	98,068,022.99
3121	Төгрөг	12,383,734.51	98,068,022.99
31211	Төрийн сангийн харилцах	12,383,734.51	98,068,022.99
35	БАРАА МАТЕРИАЛ	45,710,886.60	46,472,181.60
354	Хангамжийн материал	45,710,886.60	46,472,181.60
35420	Аж ахуйн материал	43,231,811.60	43,480,411.60
35460	Хүнсний материал	2,479,075.00	2,991,770.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	301,028,939.43	942,482,222.24
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	301,028,939.43	942,482,222.24
392	Биет хөрөнгө	290,108,772.80	931,862,055.61
39201	Барилга, байгууламж, орон сууц	266,693,205.00	926,300,959.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(27,151,218.84)	(39,976,772.28)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	47,633,138.20	55,278,538.20
39206	Хуримтлагдсан элэгдэл	(29,804,502.48)	(35,889,922.71)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	30,080,068.50	30,996,068.50
39208	Хуримтлагдсан элэгдэл	(14,845,753.03)	(18,555,997.11)
39209	Зам, гүүрийн байгууламж	33,505,000.00	33,505,000.00
39210	Хуримтлагдсан элэгдэл	(26,319,749.99)	(29,031,749.99)
39214	Бусад үндсэн хөрөнгө	14,191,500.00	14,191,500.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(4,430,614.56)	(5,538,268.00)
39217	Ном	557,700.00	582,700.00
393	Биет бус хөрөнгө	10,920,166.63	10,620,166.63
39301	Программ хангамж	1,500,000.00	1,500,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(845,833.37)	(1,145,833.37)
39303	Бусад биет бус хөрөнгө	10,266,000.00	10,266,000.00
394	Бусад хөрөнгө /ТӨҮГ/	-	-
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	359,123,560.54	1,087,022,426.83
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	359,123,560.54	1,087,022,426.83
51	Засгийн газрын хувь оролцоо	359,123,560.54	1,087,022,426.83
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	644,388,602.00	644,388,602.00
51101	Өмч: - төрийн	644,388,602.00	644,388,602.00
512	Хуримтлагдсан үр дүн	(285,265,041.46)	442,633,824.83
51210	Өмнөх үеийн үр дүн	(285,265,041.46)	(285,265,041.46)
51220	Тайлант үеийн үр дүн	-	727,898,866.29
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	359,123,560.54	1,087,022,426.83

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	963,544,050.44	1,294,393,277.42
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	514,509,173.02	667,950,754.00
120	Нийтлэг татварын бус орлого	514,509,173.02	667,950,754.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого		6,035,000.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого- Үндсэн хөрөнгө	470,426,811.42	661,915,754.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого- Бараа материал	44,082,361.60	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	449,034,877.42	626,442,523.42
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	386,918,400.00	561,853,400.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	-	561,853,400.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	386,918,400.00	-
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	-
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	62,085,361.42	64,589,123.42
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	62,085,361.42	64,589,123.42
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	31,116.00	-
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	31,116.00	-
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	480,208,615.60	566,494,411.13
21	УРСГАЛ ЗАРДАЛ	480,208,615.60	566,494,411.13
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	473,863,915.60	560,999,311.13
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	296,640,713.49	370,632,429.23
210101	Үндсэн цалин	228,184,495.35	250,982,914.61
210102	Нэмэгдэл	58,049,365.14	103,134,276.57
210104	Урамшуулал	10,406,853.00	16,515,238.05
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	39,670,968.00	44,013,242.29
210201	Тэтгэврийн даатгал	28,006,268.00	29,694,483.73
210202	Тэтгэмжийн даатгал	2,916,200.00	3,521,976.08
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,332,900.00	3,197,619.13
210204	Ажилгүйдлийн даатгал	583,300.00	688,136.22
210205	Эрүүл мэндийн даатгал	5,832,300.00	6,911,027.13
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	41,454,961.42	49,469,723.42
210301	Гэрэл, цахилгаан	3,828,641.42	6,315,037.42
210302	Түлш, халаалт	37,366,320.00	42,504,686.00
210303	Цэвэр, бохир ус	260,000.00	650,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	323,500.00	-
210401	Бичиг хэрэг	103,500.00	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	220,000.00	-
2105	Нормативт зардал	34,236,675.00	41,344,445.00
210502	Хоол, хүнс	34,236,675.00	41,344,445.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	496,100.00	15,000,000.00
210604	Урсгал засвар	496,100.00	15,000,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	814,000.00	845,400.00

210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	814,000.00	845,400.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	60,226,997.69	39,694,071.19
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	8,236,000.00	10,549,327.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,780,000.00	2,403,873.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	48,210,997.69	26,740,871.19
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	6,344,700.00	5,495,100.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	6,344,700.00	5,495,100.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	6,344,700.00	5,495,100.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	483,335,434.84	727,898,866.29
145	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	-	-
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	124,211,874.30	-
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	124,211,874.30	-
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(124,211,874.30)	-
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	359,123,560.54	727,898,866.29

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	449,034,877.42	632,477,523.42
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО		6,035,000.00
120	Нийтлэг татварын бус орлого		6,035,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого		6,035,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	449,034,877.42	626,442,523.42
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	386,918,400.00	561,853,400.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	-	561,853,400.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	386,918,400.00	-
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	62,085,361.42	64,589,123.42
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	62,085,361.42	64,589,123.42
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	31,116.00	-
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	31,116.00	-
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	433,626,142.91	540,514,834.94
21	УРСГАЛ ЗАРДАЛ	433,626,142.91	540,514,834.94
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	427,281,442.91	535,019,734.94
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	296,640,713.49	370,632,429.23
210101	Үндсэн цалин	228,184,495.35	250,982,914.61
210102	Нэмэгдэл	58,049,365.14	103,134,276.57
210104	Урамшуулал	10,406,853.00	16,515,238.05
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	39,670,968.00	44,013,242.29
210201	Тэтгэврийн даатгал	28,006,268.00	29,694,483.73
210202	Тэтгэмжийн даатгал	2,916,200.00	3,521,976.08
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,332,900.00	3,197,619.13
210204	Ажилгүйдлийн даатгал	583,300.00	688,136.22
210205	Эрүүл мэндийн даатгал	5,832,300.00	6,911,027.13
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	41,454,961.42	49,589,123.42

210301	Гэрэл, цахилгаан	3,828,641.42	6,315,037.42
210302	Түлш, халаалт	37,366,320.00	42,504,686.00
210303	Цэвэр, бохир ус	260,000.00	769,400.00
2105	Нормативт зардал	34,424,800.00	41,857,140.00
210502	Хоол, хүнс	34,424,800.00	41,857,140.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	496,100.00	15,000,000.00
210604	Урсгал засвар	496,100.00	15,000,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	814,000.00	845,400.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	814,000.00	845,400.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	13,779,900.00	13,082,400.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	9,999,900.00	10,546,200.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,780,000.00	2,536,200.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	6,344,700.00	5,495,100.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	6,344,700.00	5,495,100.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	6,344,700.00	5,495,100.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	15,408,734.51	85,927,688.48
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	3,025,000.00	6,278,400.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	3,025,000.00	6,278,400.00
2200	Дотоод эх үүсвэрээр	3,025,000.00	6,278,400.00
222001	Тоног төхөөрөмж	-	6,253,400.00
223001	Бусад хөрөнгө	3,025,000.00	25,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(3,025,000.00)	(6,278,400.00)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	12,383,734.51	79,649,288.48
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		12,383,734.51
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	12,383,734.51	98,068,022.99

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны үр дүн
А	1	2	3	4
2021 оны 12 дугаар сарын 31-нээрх үлдэгдэл	644,388,602.00	-	(285,265,041.46)	359,123,560.54
НББ-ийн бодлогын өөрчлөлт				
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	644,388,602.00	-	(285,265,041.46)	359,123,560.54
Тайлант үеийн үр дүн	-	-	727,898,866.29	727,898,866.29
2022 оны 12 дугаар сарын 31-нээрх үлдэгдэл	644,388,602.00	-	(285,265,041.46)	359,123,560.54
2023 оны 12 дугаар сарын 31-нээрх үлдэгдэл	644,388,602.00	-	(285,265,041.46)	359,123,560.54
НББ-ийн бодлогын өөрчлөлт				
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	644,388,602.00	-	(285,265,041.46)	359,123,560.54
Тайлант үеийн үр дүн	-	-	727,898,866.29	727,898,866.29
2023 оны 12 дугаар сарын 31-нээрх үлдэгдэл	644,388,602.00	-	442,633,824.83	1,087,022,426.83

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Д/Д	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү дүн	Хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	654,013,800.00	546,793,234.94	107,220,565.06	83.6
21	УРСГАЛ ЗАРДАЛ	654,013,800.00	546,793,234.94	107,220,565.06	83.6
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	648,548,700.00	535,019,734.94	113,528,965.06	82.5
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	443,687,100.00	370,632,429.23	73,054,671.00	83.5
210101	Үндсэн цалин	277,548,500.00	250,982,914.61	26,565,585.39	90.4
210102	Нэмэгдэл	149,579,400.00	103,134,276.57	46,445,123.43	68.9
210104	Урамшуулал	16,559,200.00	16,515,238.05	43,961.95	99.7
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	53,336,200.00	44,013,242.29	9,322,957.71	82.5
210201	Тэтгэврийн даатгал	36,268,400.00	29,694,483.73	6,573,916.27	81.9
210202	Тэтгэмжийн даатгал	4,267,100.00	3,521,976.08	745,123.92	82.5
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,413,500.00	3,197,619.13	215,880.87	93.7
210204	Ажилгүйдлийн даатгал	853,600.00	688,136.22	165,463.78	80.6
210205	Эрүүл мэндийн даатгал	8,563,600.00	6,911,027.13	1,652,572.87	80.7
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	58,776,700.00	49,589,123.42	9,187,576.58	84.4
210301	Гэрэл, цахилгаан	6,728,900.00	6,315,037.42	413,862.58	93.8
210302	Түлш, халаалт	51,278,400.00	42,504,686.00	8,773,714.00	82.9
210303	Цэвэр, бохир ус	769,400.00	769,400.00	-	100.0
2105	Нормативт зардал	51,512,500.00	41,857,140.00	9,655,360.00	81.3
210502	Хоол, хүнс	51,512,500.00	41,857,140.00	9,655,360.00	81.3
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	15,000,000.00	15,000,000.00	-	100.0
210604	Урсгал засвар	15,000,000.00	15,000,000.00	-	100.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	845,400.00	845,400.00	-	100.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	845,400.00	845,400.00	-	100.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	19,082,400.00	13,082,400.00	6,000,000.00	101.4
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	16,546,200.00	10,546,200.00	6,000,000.00	73.7
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,536,200.00	2,536,200.00	-	100.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	5,495,100.00	5,495,100.00	-	100.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	5,495,100.00	5,495,100.00	-	100.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	5,495,100.00	5,495,100.00	-	100.0
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	6,278,400.00	6,278,400.00	-	-
222001	Тоног төхөөрөмж	6,253,400.00	6,253,400.00	-	-
223001	Бусад хөрөнгө	25,000.00	25,000.00	-	-

	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	654,013,800.00	632,477,523.42	9,152,576.58	96.7
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	561,853,400.00	561,853,400.00	-	100.0
131001	Улсын төсвөөс санхүүжих	561,853,400.00	561,853,400.00	-	100.0
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	73,776,700.00	64,589,123.42	9,187,576.58	87.5
132001	Орон нутгийн төсвөөс	73,776,700.00	64,589,123.42	9,187,576.58	87.5
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	18,383,700.00	6,035,000.00	-	32.8
120004 1	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	6,000,000.00	6,035,000.00	(35,000.00)	100.6
120004 3	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	12,383,700.00			
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		12,383,734.51		
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		98,068,022.99		

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Сэлэнгэ аймгийн Түшиг сумын 1 дүгээр цэцэрлэг нь “Хүүхэд бүрийн сурах тэгш боломжийг бүрдүүлж, багшийн хөгжлийг дэмжин ажиллана” гэсэн эрхэм зорилгын хүрээнд үйл ажиллагаагаа явуулсан байна.

Үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- ийн өмнөх насны хүүхэд цэцэрлэгтээ айдасгүй, амар тайван суралцаж суралцахуйн хоцрогдолгүйгээр эрүүл аюулгүй тэгш хүртээмжтэй орчинд сурч хөгжих боломжийг бүрдүүлэх,
- Сургалтын байгууллагын болон багшийн ажлын гүйцэтгэлд суурилан тасралтгүй хөгжих олон хэлбэрт үйл ажиллагаанд хамрагдах,
- Багш ажилтан бүр ёс зүйн хэм хэмжээ шаардлагыг мөрдөж төсвийг төлөвлөх, үр ашигтай зарцуулахад идэвх санаачилгатай ажиллах,
- Багш нар технологийн дэвшлийг ашиглан орон зайнаас үл хамааран ээлжит хичээлийн цахим контентын сан бүрдүүлэн бүтээлчээр ашиглах,
- Мэргэжлийн хөгжлийн бүлэгтээ хамтран ажиллах зөвлөх, тэргүүлэх багшийн манлайлал үүрэг оролцоог нэмэгдүүлэх.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг дараах хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Монгол Улсын 2023 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилттэй холбоотой,

- Боловсролын ерөнхий хууль 2023 оны 07 дугаар сарын 07-нд батлагдсан,
- Хөдөлмөрийн тухай хуульд 2023 оны 07 дугаар сарын 07-нд нэмэлт өөрчлөлт орсон,
- Төрийн хэмнэлтийн тухай хуульд 2023 оны 06 дугаар сарын 16, 07 дугаар сарын 07-нд нэмэлт өөрчлөлт орсон,
- Засгийн газрын 2023 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн 241 дүгээр тогтоолоор төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоосон,
- БШУС-ын 2023 оны 06 дугаар сарын 13-ны өдрийн 1/2714 тоот албан бичгээр боловсролын байгууллагын төсвийн шинэчлэлийн хүрээнд: "Цэцэрлэгт шаардлагатай хүүхдийн тоглоом,наадгай, зөөлөн эдлэл ханган нийлүүлэх, худалдан авах ажиллагааг зохион байгуулах" чиглэлийг хүргүүлсэн гэх мэт.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналт, үйл ажиллагааны зохион байгуулалтын хэрэгжилт үр нөлөөтэй гэж үзлээ.

Тайлант онд тус байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд БШУЯ-ны Хяналт, шинжилгээ үнэлгээний газрын Дотоод аудитын хэлтсээс хяналт, шалгалт хийгдээгүй боловч сар бүрийн төсвийн гүйцэтгэлийн мэдээ, шилэн дансны мэдээллээр дамжуулан дотоод хяналт, шалгалтыг хэрэгжүүлсэн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Түшиг сумын 1 дүгээр цэцэрлэг нь 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллага нь Боловсрол, Шинжлэх Ухааны сайдын 2021 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн А/22 дугаар тушаалаар баталсан Боловсрол, Шинжлэх Ухааны салбарын төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа төсөвт байгууллагуудад мөрдөгдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг үйл ажиллагаандаа ашиглаж байна.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн хэдий ч гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжиж байгаа байгууллагын онцлогт тохироогүй, үр дүнд суурилсан төсөвлөлт,

санхүүжилт, хөрөнгө оруулалт, хөтөлбөр, арга хэмжээний бүртгэлийн талаар нарийн тусгаагүй өөрөөр хэлбэл боловсролын салбарын онцлогт тохирохгүй байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Түшиг сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгө 1,087,022.4 мянган төгрөг болж өмнөх оноос 727,898.8 мянган төгрөгөөр буюу 3 дахин өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	12,383.7	98,068.0	85,684.3
Бараа материал	45,710.9	46,472.2	761.3
Үндсэн хөрөнгө	301,029.0	942,482.2	641,453.2
Нийт хөрөнгө	359,123.6	1,087,022.4	727,898.8
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	359,123.6	1,087,022.4	727,898.8
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	359,123.6	1,087,022.4	727,898.8

Дээрх хүснэгтээс харахад дараах дансанд нөлөө бүхий өөрчлөлт гарсан байна.

Үүнд:

- Мөнгөн хөрөнгийн данс 98,068.0 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байгаа нь Төсвийн тухай хуулийн 7.9-д заасны дагуу тайлант жилийн үйл ажиллагааны зардлын хэмнэлтийг төрийн сангийн харилцах дансанд үлдэгдлээр тайлагнасантай холбоотой байна.
- Бараа материалын дансны үлдэгдэл 46,472.2 мянган төгрөг болж 761.3 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 65,424.2 мянган төгрөгийн бараа материал худалдан авсан болон 64,662.9 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулснаас шалтгаалсан байна.
- Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 942,482.2 мянган төгрөг болж 641,453.2 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд 659,607.8 мянган төгрөгийн цэцэрлэгийн барилгын өргөтгөлийг барилга байгууламж дансанд орлогоор бүртгэсэнтэй холбоотой байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 377,587.6 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 73,776.7 мянган төгрөг нийт **451,364.3** мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас нийт **202,679.5** мянган төгрөгийн орлого эх үүсвэрийг нэмэгдүүлэн тооцож улсын төсвөөс 561,853.4 мянган төгрөгөөр, орон нутгийн төсвөөс 73,776.7 мянган төгрөгөөр, өөрийн үйл ажиллагааны орлогоос 6,000.0 мянган төгрөг, урьд оны санхүүжилтээс 12,383.7 мянган төгрөг, төвлөрүүлэн нийт **654,013.8** мянган төгрөгийг зарцуулахаар баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 8 арга хэмжээг санхүүжүүлэхээр улсын төсвөөс 561,853.4 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 73,776.7 мянган төгрөг, өөрийн үйл ажиллагаанаас 6,000.0 мянган төгрөг, урьд оны санхүүжилтээс 12,383.7 мянган төгрөг, нийт 654,013.8 мянган төгрөгийн эх үүсвэрийг урсгал үйл ажиллагаанд захиран зарцуулахаар төлөвлөсөн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 546,793.2 мянган төгрөг буюу 83.6 хувьтай байгаа нь цалин хөлс, нэмэгдэл урамшлын зардлыг 73,054.7 мянган төгрөгөөр, нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг 9,322.9 мянган төгрөгөөр, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 9,187.6 мянган төгрөгөөр, хоолны зардлыг 9,655.4 мянган төгрөгөөр, бараа үйлчилгээний бусад зардлыг 6,000.0 мянган төгрөгөөр тус тус хэмнэсэнтэй холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Хөтөлбөр	д/д	Арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	зөрүү	Биелэлт
1	71801 ийн өмнөх боловсрол	1	81605- Эрүүл мэндийг дэмжих	1,268.1	1,268.1	-	100.0
		2	81807- Хүүхдийн хоолны зардал	51,512.5	41,857.1	9,655.4	
		3	81816- Хүүхдэд ээлтэй сургалтын орчин	3,134.5	3,134.5	-	100.0
		4	81823- Боловсролын багшийн сургалт	1,268.1	1,268.1	-	100.0
		5	81832- Нүүдлийн бүлэг хамруулах	1,352.1	1,352.1	-	100.0
		6	81834- Боловсролын стандарт сургалт	521,701.8	433,324.4	88,377.4	83.0
		8	80111- Төрийн өмчийн барилгын тогтмол зардал	73,776.7	64,589.1	9,187.6	87.5
				Нийт	654,013.8	546,793.2	107,220.4

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Түшиг сумын 1 дүгээр цэцэрлэг нь 2023 онд төсвийн хөрөнгөөр хүүхдийн хоол хүнсний материал худалдан авахаар 51,512.0 мянган төгрөг төсөвлөсөн байна.

Тайлант онд худалдан авах ажиллагааны урилгыг tender.gov.mn цахим сайтад байршуулж, зохион байгуулсан байна. Бэлтгэн нийлүүлэгчийг сонгон шалгаруулах худалдан авах ажиллагааны шалгаруулалтад шалгарсан Зэлтэрийн өгөөж ХХК-тай гэрээ байгуулан, худалдан авалтыг гүйцэтгэсэн байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Сэлэнгэ аймгийн Түшиг сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газартай байгуулсан гэрээний дагуу “Их наяд аудит” ХХК-ийн аудитор Х.Ариунтуяа гүйцэтгэж, хяналтыг захирал Х.Ариунзул, дараагийн шатны хяналтыг аудитын менежер Б.Батмөнх, газрын захирал, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Түшиг сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Их наяд аудит ХХК-д 2024 оны 01 дүгээр сарын 24-ны өдрийн 02 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн шатны материаллаг байдлыг 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 480,208.6 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 4,802.1 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж, шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Түшиг сумын 1 дүгээр цэцэрлэг нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хүрээнд дараах арга хэмжээнүүдийг хэрэгжүүлсэн байна. Үүнд:

- Үйл ажиллагаатай холбоотой сурталчилгаа, баяр ёслолын арга хэмжээг зохион байгуулаагүй, төсвийн хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдаж аваагүй,
- Шаардлагагүй бараа материалыг их хэмжээгээр авч нөөцлөөгүй,
- Хэвлэл захиалгын төлбөр гаргалгүй ажилласан зэрэг төсвийн шууд захирагчтай хамааралтай заалтуудыг мөрдөж, батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргасан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан *“Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”*-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны нэгдсэн системд нийт мэдээлбэл зохих 28 төрлийн 159 мэдээлэл байршуулахаас тус байгууллага нь мэдээллийг цаг хугацаанд нь ил тод, бүрэн байршуулж мэдээлсэн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тайлант онд бусад хууль, тогтоомжийн хэрэгжилтэд хамаарах алдаа, зөрчил илрээгүй болно.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторын 2023 оны 10 дугаар сарын 26-ны 123 дугаар *“Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийх тухай”* албан бичгийг хүргүүлсэн бөгөөд 2023 оны санхүүгийн тайлангийн

завсрын аудитаар 19,881.4 мянган төгрөгийн 3 алдаа илэрснээс жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар шалгахад алдааг залруулсан байна.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар шилэн дансны мэдээлэл байршуулахтай холбоотой асуудалд 1 албан шаардлага, 3 зөвлөмж өгснийг 100 хувь хэрэгжүүлэн, хариуг ирүүлсэн байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт
/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	1	-	1		100.0
Зөвлөмж	3	15,460.1	3	15,460.1	100.0
Нийт дүн	4	15,460.1	4	15,460.1	100.0

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараах асуудлыг дээд шатны төсвийн захирагчийн санхүүгийн тайланд хийх аудитын анхааралд хандуулж байна. Үүнд:

1. БШУЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга Л.Цэдэвсүрэн нь 2023 оны 07 дугаар сарын 04-ний өдрийн 2/3151 дүгээр албан бичгээр тус яамны харьяа төсвийн шууд захирагч нарт “2022 оны санхүүгийн тайланд **“Зөрчилгүй”, “Итгэл үзүүлсэн”, “Түүвэрт хамрагдсан”** гэж дүгнэгдсэн байгууллагуудын төсөв, санхүүгийн ажилтан нарт батлагдсан төсөвтөө багтаан балансын урамшууллыг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 23.2 дахь хэсгийг үндэслэн олгож болно” гэж хууль, эрхийн актад заагдаагүй **балансын урамшуулал** гэгчийг олгохыг зөвшөөрсөн байна.

Уг албан бичгийн дагуу дараах албан хаагчдын ажлын үр дүнг улирал бүр дүгнэж, үндсэн цалингийн 45.0 хүртэл хувиар тооцон үр дүнгийн мөнгөн урамшууллыг олгосон атал тус бүр нэг сарын үндсэн цалинтай тэнцэх буюу **709.4** мянган төгрөгийн урамшууллыг давхардуулан олгосон байна. Үүнд:

- Нярав Т.Батчимэгт 709.4 мянган төгрөг .

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 дэх “Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно:”, 15.1.3 : “Хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох” гэсэн заалтыг зөрчсөн байна.

2. Дээд шатны төсөв захирагчаас төсвийг зардлын эдийн засгийн ангиллаар нь бус “бараа үйлчилгээний бусад зардал” гэсэн ангиллаар бөөнд нь тусган, төлөвлөж,

баталж байгаа нь төсвийг зардлын бүлэг, зүйлээр төлөвлөж, зарцуулах, зарцуулалтад хяналт тавих зарчмыг алдагдуулж байна.

Иймд төсвийг бодит гүйцэтгэлтэй нь уялдуулан зардлын бүлэг, зүйл бүрээр төлөвлөж, зарцуулан гүйцэтгэж байх шаардлагатай байна.

3. Цаг хугацааны хязгаарлагдмал байдлаас шалтгаалан үндсэн хөрөнгийн тооллого хийж, биет тест хэрэгжүүлэх горимыг бүрэн хэрэгжүүлээгүй учир дараагийн аудитаар тулган шалгах нь зүйтэй юм.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 19,881.4 мянган төгрөгийн алдаа 3 алдаа илэрснийг аудитын явцад залруулав. Үүнд:

1. Иргэд, аж ахуйн нэгж байгууллагуудаас цахим баримтгүй 255.0 мянган төгрөгийн худалдан авалтыг гүйцэтгэсэн.
2. Цалингийн зардал, түүнтэй холбоотой 18,308.0 мянган төгрөгийн ажил гүйлгээг журналд мөнгөн сууриар бүртгэж, тайлагнасан.
3. Журналд НДШ-ийн зардлыг 1,318.4 мянган төгрөгөөр зөрүүтэй тусгаж тайлагнасан.

Аудитаар нийт 277.6 мянган төгрөгийн 2 зөрчил¹ илэрч, 277.6 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт, зөрчлийг давтан гаргахгүй байх 1 зөвлөмж өглөө.

5.1. Төлбөрийн акт

1. Шалгуур үзүүлэлтийг харгалзалгүйгээр багш нарт тус бүр 25.0 хувиар тооцон, нийт **277.7** мянган төгрөгийн ур чадварын нэмэгдлийг илүү бодож олгосон байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 6.4.1 дэх "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Боловсрол шинжлэх ухааны сайд, Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайд, Сангийн сайдын 2021 оны 02 сарын 01-ний өдрийн А/35, А/102 дугаар хамтарсан "Шалгуур үзүүлэлт шинэчлэн батлах тухай" тушаалын 1 дүгээр хавсралтын 10 дахь "Энэхүү баримт бичгийн 4,5-д заасан шалгуур үзүүлэлтийн дагуу хийсэн үнэлгээнд 60.0 ба түүнээс дээш хувь үнэлэгдсэн багш, ажилтны ажлын үр дүн, манлайлал, мэргэжлийн хөгжлийн ахиц дэвшил, амжилтын түвшнийг харгалзан нэмэгдлийг дараах хувиар тогтооно."Сум, дүүргийн түвшинд амжилт гаргасан 15%" гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Илүү олгосон нэмэгдлийг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоох

5.2. Зөвлөмж

1. Зардлын данстай холбоотой:

1.1 Илрүүлэлт: Сургуулийн үндсэн орон тоонд нягтлан бодогчоор ажиллаж буй Ж.Төгсчимэгийг тус цэцэрлэгт зэрэгцсэн хөдөлмөрийн гэрээгээр нягтлан бодогчоор

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

ажиллуулан, цалинжуулж / үндсэн цалингийн 100 хувиар тооцож / байгаа нь дараах хуулиудыг тус тус зөрчиж байна. Үүнд:

- Төрийн албаны тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1 дэх "Төрийн албан хаагч дараах нийтлэг үүрэг хүлээнэ" 37.1.17: "Үндсэн ажлаасаа гадуур хуулиар зөвшөөрснөөс бусад ажил, үүрэг эрхлэхгүй байх",
- 38 дугаар зүйлийн 38.1 дэх "Төрийн албан хаагч дараах нийтлэг эрх эдэлнэ", 38.1.6: "Багшлах, эрдэм шинжилгээний ажил эрхлэх", 38.1.7: "Хууль тогтоомжоор хориглоогүй, албан тушаалын ашиг сонирхолд харшлахгүй арга хэлбэрээр хувийн аж ахуй эрхлэх...",
- Хөдөлмөрийн тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.3 дахь "Зэрэгцсэн хөдөлмөрийн гэрээтэй ажилтны нийт ажлын цаг энэ хуулийн 84.4 -т заасан ажлын цагийн дээд хязгаарт багтах ёстой бөгөөд үүнд ажилтан, үндсэн болон зэрэгцсэн ажил олгогч тус тус хяналт тавина", 84 дүгээр зүйлийн 84.4 дэх "Долоо хоногийн ажлын цагийн дээд хязгаар нь 56 цагаас илүүгүй байна. Өдөрт ажиллах илүү цагийн хязгаар нь дөрвөн цагаас илүүгүй байна" зэрэг.

1.2 Өгсөн зөвлөмж: 2 байгууллагад зэрэгцээ хөдөлмөрөөр нягтлан бодогчийн албан тушаал эрхлүүлж буй зөрчлийг таслан зогсоож, зайлшгүй тохиолдолд цалинг өдрийн 4 цагаар бодож, 50.0 хувиас хэтрүүлэхгүй байх.

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20.5² дахь заалтад тусгасны дагуу аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, биелэлтийг 2024 оны 06 дугаар сарын 15 - ны өдрийн дотор тус тус төрийн аудитын байгууллагад ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

² Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ.

АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Д/д	Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй			
								Тоо	Дүн	Тоо	Дүн		Тоо
1	Цахим баримтгүй худалдан авалт гүйцэтгэсэн	1	255.0			1	255.0	1	255.0				
2	Цалингийн зардлыг журналд мөнгөн сууриар хөтөлж, бүртгэсэн	1	18,308.0			1	18,308.0	1	18,308.0				
3	НДШ-ийн зардлыг журналд зөрүүтэй тайлагнасан	1	1,318.4			1	1,318.4	1	1,318.4				
	Дүн	3	19,881.4			3	19,881.4	3	19,881.4				

/мянган төгрөгөөр/

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Д/д	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Нягтлан бодогчийг зэрэгцээ хөдөлмөрийн гэрээгээр ажиллуулсан	1	-										
2	Албан хаагчдад ур чадварын нэмэгдлийг илүү тооцож олгосон	1	277.6	1	277.6								
	Дүн	2	277.6	1	277.6			1					

/мянган төгрөгөөр/

Үүнээс:

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил				Үүнээс			
	Тоо		Дүн		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Дүн								
Бусад хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Дүн								
Нийт дүн								

/мянган төгрөгөөр/